



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/20/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: [bayanjargalg@audit.gov.mn](mailto:bayanjargalg@audit.gov.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.3 Албан шаардлага .....	19
4.4 Зөвлөмж .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СХЗГ	Стандарт, Хэмжил зүйн газар
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ОБГ	Онцгой байдлын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.24 № 01/48  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ,  
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Д.БАТСАЙХАН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020225

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,465,306.00</b>	<b>9,957,064.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,905,000.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	6,905,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,905,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8,560,306.00	9,957,064.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,452,100.00	5,368,408.00
35110	Тусгай зориулалттай материал	4,452,100.00	5,243,908.00
35130	Эм боох материал	00.00	124,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,108,206.00	4,588,656.00
35410	Бичиг хэргийн материал	59,000.00	309,900.00
35420	Аж ахуйн материал	2,388,906.00	2,389,756.00
35440	Түлш, шатах тослох материал	412,300.00	705,000.00
35450	Барилгын засварын материал	1,248,000.00	1,184,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,856,964.76</b>	<b>104,671,280.88</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	58,856,964.76	104,671,280.88
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	37,616,964.76	83,431,280.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	33,124,630.00	85,363,236.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,281,157.52	-12,421,736.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,800,000.00	14,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,783,333.48	-9,250,000.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,920,535.00	59,327,535.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,639,734.76	-54,709,934.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,328,978.00	8,328,978.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,852,952.48	-8,006,796.92
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	21,240,000.00	21,240,000.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,240,000.00	21,240,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>74,322,270.76</b>	<b>114,628,344.88</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,905,000.00</b>	<b>28,850.04</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,905,000.00	28,850.04
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,905,000.00	28,850.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	28,850.04
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	6,905,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,905,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>67,417,270.76</b>	<b>114,599,494.84</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	67,417,270.76	114,599,494.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,292,927.00	130,292,927.00
51101	Өмч: - төрийн	130,292,927.00	130,292,927.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-115,648,659.24	-68,466,435.16
51210	Өмнөх үеийн үр дүн	-115,648,659.24	-115,648,659.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	47,182,224.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,773,003.00	52,773,003.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>74,322,270.76</b>	<b>114,628,344.88</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>215,525,790.00</b>	<b>278,563,076.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>74,436,690.00</b>	<b>145,390,876.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	74,436,690.00	145,390,876.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,436,690.00	145,390,876.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,436,690.00	90,142,920.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	55,247,956.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>141,089,100.00</b>	<b>133,172,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	141,089,100.00	133,172,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141,089,100.00	133,172,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>218,517,382.82</b>	<b>231,199,909.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,517,382.82</b>	<b>231,199,909.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	199,319,956.82	203,196,489.59
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	136,234,823.60	140,425,159.43
210101	Үндсэн цалин	110,535,473.60	105,151,806.83
210102	Нэмэгдэл	22,709,930.00	31,516,141.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,989,420.00	3,757,211.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,913,740.40	18,216,462.44
210201	Тэтгэврийн даатгал	15,115,778.31	12,790,062.00
210202	Тэтгэмжийн даатгал	459,849.14	1,424,066.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	367,877.15	1,119,094.45
210204	Ажилгүйдлийн даатгал	88,205.85	262,113.24
210205	Эрүүл мэндийн даатгал	882,029.95	2,621,125.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,276,083.00	17,582,653.29
210301	Гэрэл, цахилгаан	889,283.00	1,070,663.29
210302	Түлш, халаалт	14,897,520.00	14,897,520.00
210303	Цэвэр, бохир ус	489,280.00	1,614,470.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,428,800.00	6,615,938.55
210401	Бичиг хэрэг	2,185,560.00	1,101,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,502,000.00	2,781,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,169,220.00	1,740,908.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,149,070.00	751,930.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	92,950.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,602,204.00	294,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	499,654.00	294,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,102,550.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,664,860.00	2,670,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	750,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	640,000.00
210604	Урсгал засвар	1,914,860.00	2,030,870.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,354,000.00	4,940,000.00
210702	Догоод албан томилолт	5,354,000.00	4,940,000.00

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,802,648.00</b>	<b>2,962,016.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	396,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	497,200.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,000.00	294,068.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,928.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	315,000.00	320,000.00
210807	Газрын төлбөр	63,720.00	63,720.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	1,795,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,042,797.82</b>	<b>9,489,189.88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,164,000.00	943,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	714,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,878,797.82	7,831,289.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,197,426.00</b>	<b>28,003,420.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>560,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	560,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,497,426.00</b>	<b>27,443,420.33</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,497,426.00	27,443,420.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-2,991,592.82</b>	<b>47,363,166.08</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>180,942.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	180,942.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-180,942.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-2,991,592.82</b>	<b>47,182,224.08</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>215,525,790.00</b>	<b>223,315,120.00</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	0.00	0.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>74,436,690.00</b>	<b>90,142,920.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	74,436,690.00	90,142,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,436,690.00	90,142,920.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,436,690.00	90,142,920.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>141,089,100.00</b>	<b>133,172,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	141,089,100.00	133,172,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141,089,100.00	133,172,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>215,525,790.00</b>	<b>223,315,120.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>215,525,790.00</b>	<b>223,315,120.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>196,328,364.00</b>	<b>195,311,699.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	136,234,823.60	140,396,316.60
210101	Үндсэн цалин	110,535,473.60	105,122,964.00
210102	Нэмэгдэл	22,709,930.00	31,506,852.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,989,420.00	3,766,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	16,913,740.40	18,216,455.23
210201	Тэтгэврийн даатгал	15,115,778.31	12,790,056.18
210202	Тэтгэмжийн даатгал	459,849.14	1,424,066.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	367,877.15	1,119,093.68
210204	Ажилгүйдлийн даатгал	88,205.85	262,112.46
210205	Эрүүл мэндийн даатгал	882,029.95	2,621,125.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,276,083.00	17,582,653.29
210301	Гэрэл, цахилгаан	889,283.00	1,070,663.29
210302	Түлш, халаалт	14,897,520.00	14,897,520.00
210303	Цэвэр, бохир ус	489,280.00	1,614,470.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,745,230.00	7,166,138.55
210401	Бичиг хэрэг	1,190,460.00	1,308,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,662,300.00	3,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,169,220.00	1,740,908.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,393,250.00	826,330.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,499,004.00	418,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	499,654.00	418,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	999,350.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,299,485.00	1,414,620.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,999,825.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	640,000.00
210604	Урсгал засвар	2,499,660.00	774,620.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,354,000.00	4,940,000.00
210702	Дотоод албан томилолт	5,354,000.00	4,940,000.00

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,562,648.00	1,721,716.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	396,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	497,200.00	397,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,000.00	294,068.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,928.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	315,000.00	275,000.00
210807	Газрын төлбөр	63,720.00	63,720.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	34,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	760,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,443,350.00	3,455,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,443,350.00	2,430,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,024,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,197,426.00</b>	<b>28,003,420.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	700,000.00	560,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	560,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	18,497,426.00	27,443,420.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,497,426.00	27,443,420.33
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	130,292,927.00	52,773,003.00	-112,657,066.42	00.00	70,408,863.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>-112,657,066.42</b>	<b>00.00</b>	<b>70,408,863.58</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-2,991,592.82	00.00	-2,991,592.82
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>-115,648,659.24</b>	<b>00.00</b>	<b>67,417,270.76</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>-115,648,659.24</b>	<b>00.00</b>	<b>67,417,270.76</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>-115,648,659.24</b>	<b>00.00</b>	<b>67,417,270.76</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	47,182,224.08	00.00	47,182,224.08
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>130,292,927.00</b>	<b>52,773,003.00</b>	<b>-68,466,435.16</b>	<b>00.00</b>	<b>114,599,494.84</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Зүүллэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>221,089,100.00</b>	<b>197,028,364.00</b>	<b>203,172,200.00</b>	<b>195,871,699.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>221,089,100.00</b>	<b>197,028,364.00</b>	<b>203,172,200.00</b>	<b>195,871,699.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>220,389,100.00</b>	<b>196,328,364.00</b>	<b>202,612,200.00</b>	<b>195,311,699.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>150,130,300.00</b>	<b>136,234,823.60</b>	<b>143,968,700.00</b>	<b>140,396,316.60</b>
210101	Үндсэн цалин	113,788,200.00	110,535,473.60	111,706,600.00	105,122,964.00
210102	Нэмэгдэл	32,035,600.00	22,709,930.00	27,955,600.00	31,506,852.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,306,500.00	2,989,420.00	4,306,500.00	3,766,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,267,600.00</b>	<b>16,913,740.40</b>	<b>19,435,700.00</b>	<b>18,216,455.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,262,400.00	15,111,578.31	13,677,000.00	12,790,056.18
210202	Тэтгэмжийн даатгал	1,501,300.00	464,049.14	1,439,700.00	1,424,066.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,201,000.00	367,877.15	1,151,700.00	1,119,093.68
210204	Ажилгүйдлийн даатгал	300,300.00	88,205.85	287,900.00	262,112.46
210205	Эрүүл мэндийн даатгал	3,002,600.00	882,029.95	2,879,400.00	2,621,125.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,244,700.00</b>	<b>16,276,083.00</b>	<b>18,103,200.00</b>	<b>17,582,653.29</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,646,700.00	889,283.00	1,427,100.00	1,070,663.29
210302	Түлш, халаалт	16,734,400.00	14,897,520.00	15,061,000.00	14,897,520.00
210303	Цэвэр, бохир ус	1,863,600.00	489,280.00	1,615,100.00	1,614,470.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,793,000.00</b>	<b>7,745,230.00</b>	<b>7,282,700.00</b>	<b>7,166,138.55</b>
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,196,290.00	1,310,000.00	1,308,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,663,000.00	3,662,300.00	3,050,400.00	3,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,163,390.00	1,820,000.00	1,740,908.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,000.00	330,000.00	272,300.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,000.00	1,393,250.00	830,000.00	826,330.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,499,004.00</b>	<b>420,000.00</b>	<b>418,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	499,654.00	420,000.00	418,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	999,350.00		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,300,000.00</b>	<b>6,299,485.00</b>	<b>1,440,000.00</b>	<b>1,414,620.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	2,999,825.00		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00	640,000.00	640,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,499,660.00	800,000.00	774,620.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>5,354,000.00</b>	<b>6,340,000.00</b>	<b>4,940,000.00</b>
210702	Догоол албан томиллолт	8,000,000.00	5,354,000.00	6,340,000.00	4,940,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,677,500.00</b>	<b>2,562,648.00</b>	<b>2,031,100.00</b>	<b>1,721,716.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	400,000.00	396,800.00		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	497,200.00	497,200.00	397,800.00	397,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,000.00	473,000.00	473,000.00	294,068.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,500.00	26,928.00	106,500.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,800.00	30,000.00	30,800.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	315,000.00	315,000.00	315,000.00	275,000.00
210807	Газрын төлбөр	85,000.00	63,720.00	68,000.00	63,720.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-	40,000.00	34,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	799,000.00	760,000.00	600,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,476,000.00</b>	<b>3,443,350.00</b>	<b>3,590,800.00</b>	<b>3,455,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,476,000.00	2,443,350.00	2,430,800.00	2,430,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	1,160,000.00	1,024,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>700,000.00</b>	<b>700,000.00</b>	<b>560,000.00</b>	<b>560,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>700,000.00</b>	<b>560,000.00</b>	<b>560,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	700,000.00	560,000.00	560,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>221,089,100.00</b>	<b>197,028,364.00</b>	<b>203,172,200.00</b>	<b>195,871,699.67</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>141,089,100.00</b>	<b>122,591,674.00</b>	<b>133,172,200.00</b>	<b>105,728,779.67</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	141,089,100.00	122,591,674.00	133,172,200.00	105,728,779.67
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>80,000,000.00</b>	<b>74,436,690.00</b>	<b>70,000,000.00</b>	<b>90,142,920.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000,000.00	74,436,690.00	70,000,000.00	90,142,920.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>14.00</b>	<b>14.00</b>	<b>14.00</b>	<b>14.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	1.00	1.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь тус аймгийн нутаг дэвсгэрт Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг, Стандарт, Хэмжил зүйн газарт санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Монгол улсын Шадар сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт хийж, тохирлын гэрчилгээ олгох
- Хэмжих хэрэгсэл, хэмжүүр баталгаажуулалтыг хүндийн хэмжил, цахилгаан соронзонгийн хэмжил, эзлэхүүн багтаамж хийн шингэний зарцуулалтын хэмжээ
- Стандарт мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлж, салбар сан үүсгэн стандартыг цахим хэлбэрээр хадгалах
- Сорьцын хяналт тавих

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг Стандарт, Хэмжил зүйн газрын Стратеги төлөвлөлт дотоод аудитын газраас хяналт шалгалт хийснийг гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглана гэж шийдвэрлэсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 3,277.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,458.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 1,5 хувиар буюу 3,435.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 2,576.6 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 118.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн "Acolous" программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

### **Орлого:**

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 133,172.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 90,142.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 55,248.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 278,563.1 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 133,172.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 90,142.9 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 223,315.1 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

### **Зардал:**

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 231,199.9 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 223,315.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 195,871.7 мянган төгрөг зарцуулж тайлагнасан байна.

### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140009001 тоот дансанд 2021 онд 223,315.1 мянган төгрөгийн орлого, 223,315.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140009401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй 0 үлдэгдэлтэй байна.

### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 135,914.1 мянган төгрөг, тайлант онд аймгийн шилжих үлдэгдлээс 52,238.6 мянган төгрөгөөр барилгын дээвэр, гадна фасадыг сайжруулалт хийж, өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдсөний дагуу 407.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, тооллогоор 1,000.0 мянган төгрөгийн хөрөнгө илрүүлэн бүртгэж, нийт 53,645.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн орлого авч, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 189,559.7 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 8,560.3 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 10,249.1 мянган төгрөг, СХЗГ-с үнэ төлбөргүй ирсэн 1,155.0 мянган төгрөгийн гэрчилгээнүүд, аймгийн ОБГ-с үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 50.0 мянган төгрөгийн маск, тооллогоор илрүүлэн 397.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг данс бүртгэлд орлого авч, нийт 11,851.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 9,866.8 мянган төгрөг, өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдсөний дагуу 407.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөнд шилжүүлж, байгууллагын даргын шийдвэрээр 180.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг акталж, нийт 10,454.7 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 9,957.1 мянган төгрөг байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Тайлант жилийн авлагын эхний үлдэгдэл 6,905.0 мянган төгрөг, нэмэгдсэн 1,979.1 мянган төгрөг, хасагдсан 8,884.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 6,905.0 мянган төгрөг, нэмэгдсэн 223,470.0 мянган төгрөг, хасагдсан 230,346.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 23 байгууллагатай тооцооны үлдэгдлийн баталгаагаар тооцоо нийлж баримтжуулсан байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 9,957.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 104,671.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	6,905.0	0	-6,905.0
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	8,560.3	9,957.1	1,396.8
Үндсэн хөрөнгө	58,857.0	104,671.3	45,814.3
Нийт хөрөнгө	74,322.3	114,628.4	40,306.1
Өр төлбөр	6,905.0	28.9	-6,876.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	67,417.3	114,599.5	47,182.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	74,322.3	114,628.4	40,306.1

Авлагын данс эцсийн үлдэгдэлгүй болж, оны эхний үлдэгдлээс 6,905.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,957.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 1,396.8 мянган төгрөгөөр өссөн нь СХЗГ, ОБГ-с 1,205.0 мянган төгрөгийн материал, тооллогоор 397.4 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй шилжүүлж авсан нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 104,671.3 мянган төгрөг болж 45,814.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аймгийн шилжих үлдэгдлээс 52,238.6 мянган төгрөгөөр барилгын дээвэр, гадна фасадыг сайжруулалт хийж, бараа материалын данснаас 407.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, нийт 53,645.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 7,831.3 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 114,628.4 мянган төгрөг болж, 40,306.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 237,942.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний урсгал зардалд 237,942.5 мянган төгрөг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 17,342.6 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 130,600.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 90,000.0 мянган төгрөг, нийт 220,600.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

СХЗГ-с 2021 оны 5 дугаар сард 2 удаа төсөвт тодотгол хийгдэж, улсын төсвөөс санхүүжих эх үүсвэр 133,172.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 70,000.0 мянган төгрөг, нийт 203,172.2 мянган төгрөгөөр баталж, төсвийг 17,427.8 мянган төгрөгөөр бууруулсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 133,172.2 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлого 90,142.9 мянган төгрөг, нийт 223,315.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаандаа 195,871.7 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 27,443.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 195,871.7 мянган төгрөг буюу 87.7 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн III-р хуралдааны 03 дугаар тогтоолоор Стандарт, Хэмжил Зүйн хэлтсийн барилгын дээврийн засвар, гадна фасадны засварын ажилд 55.7 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу тендер зарлан Улаанбаатар хотын Чандмань Хонгор Групп ХХК шалгарч 52,238.6 мянган төгрөгөөр барилгын дээвэр, гадна фасадын засварын ажлыг гүйцэтгэж хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

СХЗГ-с 2021 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 90,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөө өгөөд тодотголоор 70,000.0 мянган төгрөг болгож өөрчилсөн. Гүйцэтгэлээр 90,142.9 мянган төгрөг төвлөрүүлж 128.8 хувиар биелүүлсэн байна. Энэ нь үйл ажиллагааны орлогыг тодотгосон төлөвлөгөөгөөр бууруулах шаардлагагүй байсан гэж дүгнэх үндэслэлтэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллийг хуулийн хугацаанд нь 142 мэдээлэл байршуулж, 6 мэдээлэл хугацаа хоцроож 95,9 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын тооллогын комисс тооллогын бүртгэл үйлдэж, нягтлан бодогч тооцоо бодсон актаар баримтжуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлснийг байгууллагын даргын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн Б/45 тушаалаар холбогдох хүмүүст хариуцлага тооцож хэрэгжүүлсэн байна.

Төсвийн тухай хуульд заасан цаглабарт санхүүгийн тайлангаа ирүүлэх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үндсэн хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл ирмэгц камер, дэлгэц, хурууны хээ уншигчийг тоног төхөөрөмж дансанд бүртгэх зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж Стандарт хэмжил зүйн газрын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №60 тоот албан бичгээр төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлж, дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 32,261.4 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 29,130.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 705.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,425.7 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангуудын уялдааг шалгахад цэвэр өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны зэрэгцүүлсэн үзүүлэлтийг алдаатай тайлагнасан, санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардалд 1,687.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 27,443.4 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.3 Албан шаардлага

Төсвийн хуваариар сар бүр 254.2 мянган төгрөгийн шатахууны зардал зарцуулах бөгөөд 2021 оны жилийн эцсийн бараа материалын тооллогын бүртгэлээр 705.0 мянган төгрөгийн шатах тослох материалын үлдэгдэлтэй байгаа нь 2-3 сарын илүү нөөцийг бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д “ жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн” зарчимтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “үнэлгээ”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Худалдан авалттай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Харилцагч 3 байгууллагаас э баримт, э посоор баримтжуулах 1,675.7 мянган төгрөгийн худалдан авалтыг баталгаажуулаагүй зөрчил байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

##### Өгсөн зөвлөмж:

НХМаягт ТМ-5 ebarimt-нд үндэслэн санхүүгийн төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримтаар санхүүгийн бүх гүйлгээг баталгаажуулж байх

#### 2. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал

##### 1.2. Илрүүлэлт:

Тайлант онд сар бүр 254.2 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг зарцуулах төсвийн хуваарьтай бөгөөд 12 дугаар сард 8 удаагийн зарцуулалтаар 750.0 мянган төгрөгийн шатах тослох материалыг зарцуулж, шатахууны тооцоог бодоогүй алдаа зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож байх

**3. Нийцлийн аудитын асуудал**

1.3. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь 142 мэдээлэл байршуулж, 6 мэдээлэл хугацаа хоцроож 95,9 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Байршуулсан мэдээлэлүүд үнэн зөв, бодитой, ач холбогдолтой биш, PDF файлаар оруулаагүй байгаа зэрэг зөрчил байна. Энэ нь “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" зарчмууд хангагдахгүй байна

Өгсөн зөвлөмж:

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Стандарт, Хэмжил зүйн хэлтэс	5	32,261.4	1	29,130.7	0	0.0	1	705.0	3	2,425.7